

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.10.24, №4 (120)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№502

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

СААРАЛ ШҮҮХ

ДеФакто **ТОЙМ**


➤ МОНГОЛЫН КЛИЕНТЕЛИСТ УЛС ТӨР

“Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” номын зохиогч Чехийн улс төр судлаач Михаль Клима өнгөрч байгаа долоо хоногт монголд ирж уулзалт, лекц зохион байгуулаа.

➤ МОНГОЛ, УНГАР, ПОЛЬШ ОРНУУДЫН ТББ-ЫН ИНСТҮҮЦИЙН ОРЧИНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол улс анх иргэний нийгмийн салбарын гол оролцогч болох төрийн бус байгууллагын тухай хуулиа 1997 онд батлаж байв. Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) өнгөрсөн оноос тус хуулийг шинэчлэн найруулж ‘Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай’ хуулийн төслийг боловсруулаад байна.

IV НҮҮРТ



2019 оны 10-р сарын 13-18-нд Парис хотод Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын (FATF) жилийн хурал болж Монгол, Исланд, Зимбабве улсуудыг “саарал жагсаалтад” оруулснаа зарлав. Энэ байгууллага улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тэмцэхийн тулд юу хийхийг зөвлөж (40 зөвлөмж), үр дүнг нь хэмжин (11 үзүүлэлтээр) тайлан гаргадаг. Үүнээс МУ таван зөвлөмжийг хэрэгжүүлээгүй учир үр дүн тааруу (4 үзүүлэлт) гарсан юм. Энэ тухай би өмнөх “Саарал төр” нийтлэлээрээ хүргэсэн.

Энэ байгууллага хоёр жагсаалт гаргадаг. Нэг нь хар буюу онцгой анхаарах жагсаалт. Нөгөө нь саарал буюу хяналтын жагсаалт. Саарал жагсаалтад орсон оронтой хийх санхүүгийн үйл ажиллагааг хорихгүй, гэхдээ эрсдлийг тооцохдоо юунд анхаарахыг зөвлөдөг. Үр дүнд нь олон улсын санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид тухайн улсад тун болгоомжтой ханддаг, үйл ажиллагааны хүрээгээ өөрсдөө хумидаг.

СААРАЛ БОЛСОН ШАЛТГААН

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар үүнийг “Буруу бодлого, буруу үйлдэл...” гээд үүнийгээ “хүлээн зөвшөөрч, засахгүй явсан. Хамгийн том нөлөө үзүүлсэн нь Өршөөлийн хууль” гэв. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж “Ил тодын тухай хууль 2015 оны 1-р сард их хуралд орж ирээд буцсан. Дараа нь наадмын үеэр хүчээр баталсан” гэв.

“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль” нэртэй энэ өршөөлийн хууль 2015.08.07-2016.02.20-ны хооронд үйлчилсэн. Энэ хуулиар урьд өмнө нь мэдэгдээгүй өмчөө (бэлэн мөнгө, үл хөдлөх хөрөнгө) бүртгүүлвэл татвараа төлнө, эх үүсвэрийг нь асуухгүй, эрүүгийн хэрэг үүсгэхгүй, хариуцлага тооцохгүй, мэдээллийг нууцална гэсэн. Хуулийн хугацаанд манай улсын нэг жилийн эдийн засгаас том буюу, 8794 иргэн, 25 мянган аж ахуйн нэгж, харьяалалгүй 448 иргэний нийт 33,3 их наяд төгрөгийн хөрөнгө ил болов.



▶ FATF-ийн APG (Ази, Номхон далайн бүсийн байгууллага) байгууллага нь Монголд хөндлөнгийн, хараат бус экспэрт явуулж 2017 онд мөнгө угаалтын байдалд үнэлгээ хийсэн. Тэдний тайланд юунд анхаарах, засахыг тодорхой зөвлөсөн. Харин тэдгээр зөвлөмжийг төр засаг нь бүрэн биелүүлж чадаагүй учир Монгол улс саарал жагсаалтад орчихлоо.

Энэ *тайланд* МУ мөнгө угаах гэмт хэргийн аюулд өртөж болохуйц эмзэг (15-р хуудас) байна. Хамгийн өндөр эрсдэлтэй нь залилан, байгаль орчны гэмт хэрэг, татвараас зугтах, авлига байна. Дунд зэргийн эрсдэлтэй нь хар тамхи, хууль бусаар бараа хил давуулах, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай дээрэм гэжээ.

Дээрх төрлийн гэмт хэргүүдээс олсон орлогоо Монголд болон

гадаадад угааж байна. Орлого нь Монгол дотроо үл хөдлөх хөрөнгө, автомашин/тоног төхөөрөмж, хэрэглээний бусад өндөр үнэтэй зүйлс худалдаж авахад зарцуулагдаж байна.

Мөн хуулийн этгээдээр дамжуулан барилгын салбарт мөнгө угааж байна. Авлигын мөнгийг голдуу гэр бүлийнхээ гишүүдийн банкны дансаар авдаг. Тэгээд гадаадын банк, оффшор данс, бусад санхүүгийн байгууллагууд руу шилжүүлж байна. Зарим тохиолдолд банкны системээр дамжуулан буцааж Монголд оруулдаг. Монголын хамгийн эмзэг нь банкны салбар гэжээ.

Монголын арилжааны банкууд өөрийн хөрөнгөө нэмэхдээ хууль бус үйлдэл орсон эсэхийг хөндлөнгийн санхүүгийн хяналтын байгууллагаар шалгуулахыг ОУВС шаардаж, хийлгүүлсэн нь тохиолдлын хэрэг биш. Энэ шалгалтын тайланг Монголбанк удалгүй олон нийтэд мэдэгдэх байх аа.



ШҮҮХИЙН ГАЦАА

Мөнгө угаахтай холбогдсон хэргүүдийг монголын шүүх шийдэж чадахгүй байна. Олон хэрэг мөрдөгддөг. Өндөр албан тушаалтай олон хүнийг баривчилж байсан. Хоёр ч Ерөнхий сайд асан, Сангийн сайд асан, төрийн өмчит компанийн удирдлагууд, хамгийн том банкны эзэн гэх мэт. Монгол улсад гүйцэтгэх засаглал, шүүх, хүчний байгууллагууд хоорондоо хамтарч ажиллахгүй байна гэж дээрх тайланд бичжээ. Товчоор, шударга ёс байхгүй, хангах механизм нь ажиллахгүй байна.

АТГ мөрдөж, шалгаад хэдэн зуун хэргийг шүүхэд шилжүүлэх хүсэлтээ прокурорт явуулдаг боловч, тав аравхан хувь нь шүүхэд очдог.

Бусад нь яасан тухай прокурор иргэдэд тайлан тавьдаггүй. Шүүхэд очсон хэргүүд бараг бүгд л есөн шидийн шалтаг, шалтгаанаар шүүх хурал нь хойшилсоор, хөөн хэлэлцэх хугацаа гэгч нь дуусаад хаагддаг гажиг зуршил тогтчихсон. Энэ бол шүүх тогтолцоо шударга үнэнд биш, авлигачдад үйлчлэх болсныг тод харуулж байна. Монгол улсын прокурор, шүүхийн систем авлигачдын гар хөл болсноос мөнгө угаах хэрэг газар авч, улс дотроо шийдэж чадахгүй хэмжээнд хүрч олон улсын байгууллага саарал жагсаалтад оруулсан нь энэ.

Нийтийн хөрөнгийг зувчуулсан авлигачид нь завшиж, нийт иргэд

нь ядуурч, аргаа бараад дүрвэж байгааг хэзээ болтол иргэд тэвчих юм бэ? Авлигын хохирлыг иргэд төлж байна. Иргэд дараагийн сонгуульд найдлага тавьдаг ч, эрх баригчид сонгуулийн хуулийг өөрсдөдөө ашигтайгаар үргэлж өөрчилсөөр ирсэн. Яг одоо Үндсэн хуулиа өөрсдөдөө ашигтайгаар өөрчлөх тухай бүтэн жил ярьж, шүүхийн гацаанаас иргэдийн анхаарлыг сарниулж, 2020 оны сонгуулийг хоног тоолон хүлээж сууна.

Үнэндээ монголын шүүх засаглал саарал жагсаалтад орлоо гэсэн үг.

2019.10.23

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.10.20-ны дугаар
Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МОНГОЛЫН КЛИЕНТЕЛИСТ УЛС ТӨР

“Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” номын зохиогч Чехийн улс төр судлаач Михаль Клима өнгөрч байгаа долоо хоногт монголд ирж уулзалт, лекц зохион байгууллаа.

Манайх шиг эдийн засаг буурай орнуудад хөгжлийн хамгийн том сорилт болоод буй авлигыг үндсэндээ хоёр төрлийн үзэгдэлд Фрэнсис Фукуяама хуваан тайлбарлажээ. Эхнийх нь төрийн янз бүрийн лиценз, зохицуулалтаас үүсдэг Рент (rent-seeking) гэх үзэгдэл. Рент нь эдийн засагт бодит зардлаас давсан хэт өндөр ашиг олохыг хэлдэг бөгөөд энэ бол байгалийн баялагтай орнуудын нийтлэг зовлон. Энгийн үгээр хэлвэл зовлон багатайгаар өндөр ашиг олохыг рент гэж болно. Төрийн эрх мэдлээ ашиглаж зовлон багатайгаар бизнес хийх сонирхолтой бүлгийг “rent-seekers” гэнэ.

Удаах үзэгдлийг клиентелизм (clientelism) гэдэг. Клиентелизм гэдэг нь клиент буюу үйлчлүүлэгч гэдэг үгнээс үүсэлтэй бөгөөд бизнесийн хамтрагч хэлбэрээр улс төрийн эрх мэдэлд гарах, дараа нь эрх мэдлээ ашиглаж үйлчлүүлэгчиддээ ашигтай боломж олгохыг хэлдэг. Монголд ил тод болж буй 60 тэрбумын гэх, ЖДҮ зээлийг УИХ-ын гишүүд хувааж авсан зэрэг хэргүүд клиентелизм манайд өргөн дэлгэр цэцэглэн хөгжиж ирсний бодит баталгаа. Энэ үзэгдэлд бас Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Хөгжлийн банкны зээл, концессийн гэрээнүүд зэрэг урт жагсаалт хамрагдана. Товчхондоо манай өнөөгийн улс төрийн орчныг клиентелист улс төр гэж тодорхойлж болно.

Клиентелизм мэдээж шинэ зүйл биш. 19-р зууны АНУ-д ч сонгуулиар ялсан нам нь нийтийн албыг худалдан хуваадаг клиентелизмийн зуршил тогтоод байлаа. Нэгэнт амласан албан тушаалдаа томилоогүй гэж шинээр сонгогдсон ерөнхийлөгч

Жеймс Гарфийлдийн амийг хүртэл хороосон байдаг. Энэ хэрэг явдал мерит зарчимд суурилсан Төрийн албаны тухай хууль батлахад хүргэж улс төрийн наймаанаас нийтийн албаа хамгаалах болжээ. Мөн Австрид 20-р зуунд орон нутгийн цэцэрлэг, сургуулийн удирдлагуудаас эхлээд төрийн албан тушаалыг хоёр нам нь хувааж авдаг “Пропорц” гэх систем дэлгэрсэн

байлаа. Эдгээр түүхэн жишээ нь клиентелизм өнөөгийн ардчилсан хөгжингүй орнуудад ч тодорхой цаг үед оршиж байсныг харуулж байна.

Ардчиллаас өмнө иргэний нийгмийн хөрс суурь бүрдээгүй манайхтай адил шилжилт хийсэн зарим пост-коммунист орнуудад нийгэм, улс төрийн ижил төсөөтэй үйл явдлууд өрнөж байна. 1990 оноос өмнө эдгээр орнуудын түүхийн тодорхой хэсгийг тоталитар дэглэм тодорхойлж байв. Тоталитар дэглэм бол юуны өмнө иргэний нийгмийг устгадаг. Ийм ч учраас тоталитар дэглэмээс ардчилалд шилжиж буй орнуудад иргэний нийгмийн суурь хөрс байхгүй байлаа. Улс төр судлаач Михаль



Климагийн “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” бүтээлдээ харуулсан Чех орны сүүлийн 25 жилийн клиентелизмийн тогтолцоо, улс төрийн намуудын хямралын дүр зураг нь Монголтой тун төсөөтэй харагдаж байна. Клима номондоо пост коммунист орнуудад улс төрийн намууд дээрээсээ, бас доороосоо иргэдэд биш санхүүжүүлэгч эзэддээ эзлэгдэж, улс төрийн клиентелист тогтолцоо бий болсныг тод бичсэн байдаг. Чехийн нийгэм, улс төрийн орчинд буй иргэний нийгмийн хоосон орон зай нь энэ улсын ардчилсан шилжилтийн хамгийн эмзэг цэг нь болоод байна гэж тэр дүгнэсэн байдаг.

Монгол улсын ардчилсан шилжилтийн 30 жилийн авлига, түүнд хамаарах үзэгдлүүд тодорхойлсон бол


дараагийн гурван арваныг нийгэм, улс төрөө хэрхэн бүрдүүлэх нь иргэний нийгмээс ихээхэн шалтгаалах юм аа. Нийтийн засаглалын хямралаас гарч, засч тохинуулах буюу клиентелист тогтолцооноос салах түлхүүр нь хүчтэй иргэний нийгэм. Намууд нь улс төрийн тогтолцооны дэд системийн хувьд иргэний нийгэм, чөлөөт хэвлэл зэрэг бусад системүүдтэйгээ харилцан уялдаатай учир, өөрөө дангаараа шинэчлэгдэх боломжгүй. Харин улс төрийн намын инстүүчлэл тодорхой түвшинд хүрсэн орнууд ардчиллаас эргэж буцдаггүй гэсэн дүгнэлтийг Английн судлаач Фернандо Касал Бертао 60-аад орны улс төрийн намуудыг инстүүчлэлийн талаас нь судлаж гаргасан байдаг. Улс төрийн нам, хэвлэл мэдээллийн

хэрэгсэл нь нийтийн санаа бодлыг хэлбэршүүлж, хүсэл зоригийг илүү зохион байгуулалттайгаар илэрхийлэх үүрэгтэй сувгууд юм. Гэвч өнөөдөр манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн 70 гаруй хувь нь улс төрийн өндөр албан тушаалтнуудын өмч болжээ. Харин улс төрийн намууд нь нийтийн санаа бодлыг төлөвшүүлэхэд оролцохын оронд клиентелизмийг хэрэгжүүлдэг бүтэц болж хувирав.

Эцэст нь Михаль Климагийн хэлснээр “Хэрэв иргэний нийгэм нь өөрийн орлуулшгүй үүргээ гүйцэтгэж чадахгүй юм бол тухайн оронд зөвхөн нэр төдий клиентелист ардчилал, эсвэл бүр авторитар дэглэм л бүрдэх болно.

МОНГОЛ, УНГАР, ПОЛЬШ ОРНУУДЫН ТББ-ЫН ИНСТҮҮЦИЙН ОРЧИНД ХИЙСЭН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Монгол улс анх иргэний нийгмийн салбарын гол оролцогч болох төрийн бус байгууллагын тухай хуулиа 1997 онд батлаж байв. Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХЯ) өнгөрсөн оноос тус хуулийг шинэчлэн найруулж ‘Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай’ хуулийн төслийг боловсруулаад байна. Энэ хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд хамтран тус хуульд санал, бодлоо хүргэхээр цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсаар байгаа. Энэ цуврал хэлэлцүүлгийн ээлжит уулзалт 10-р сарын 15-нд болж иргэний нийгмийн байгууллагууд, зарим УИХ-ын гишүүд болон ХЗДХЯ-ны төлөөлөл оролцов. Энэ удаагийн хэлэлцүүлгээр Дефакто



DeFacto
INDEPENDENT RESEARCH INSTITUTE

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН
ИНСТҮҮЦИЙН ОРЧНЫ
ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ**

Монгол, Унгар, Польш орнуудын жишээн дээр

Институт Монгол, Унгар, Польш орнуудын ТББ-ын инстүүцийн орчинд хийсэн харьцуулсан судалгаагаа танилцууллаа.

Харьцуулсан судалгаа нь тухайн зохицуулалтын орчноос сайн туршлага, ижил төстэй болон ялгаатай талуудыг олж илрүүлэхэд ач холбогдолтой байдаг. Иймд манай ТББ-уудын орчин, нөхцөл ямар байгаа вэ, одоо өргөн барих гэж байгаа “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай” хуулийн төсөл нь ямар боломж бас эрсдэл дагуулах вэ, пост-коммунист орнуудтайгаа харьцуулахад ямар байна вэ зэргийг тодруулахаар Унгар, Польш орнуудын жишээн дээр харьцуулсан судалгааг хийсэн.

СУДАЛГААНЫ ГОЛ ДҮГНЭЛТ:

Ардчиллаас авторитар дэглэм рүү буцах үйл явцад хамгийн түрүүнд улс төрийн сөрөг хүчнүүд, зарим иргэний нийгмийн төлөөлөл хоморгод өртдөг. Учир нь тэд хамгийн түрүүнд авторитар удирдагчдын үйлдлүүдийг эсэргүүцдэг болохоор. Ардчилалд иргэний нийгмийн хөгжил ба түүний оролцоо туйлын чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол, Унгар, Польш орнууд нь коммунизмын дараагаар ТББ-уудад хамаарах иргэний нийгмийн зохицуулалтаа батлан иргэний нийгмийн хөгжлийн үндэс сууриа тавьжээ. Гэсэн хэдий ч эдгээр орнуудад гадаадын санхүүжилтийг хязгаарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр хүндийг нь унагах, зарим хуулиар дамжуулан эрхийг нь хязгаарлах зэргээр иргэний нийгмийн орон зайг хумих үйл явц өрнөж эхлээд байна.

Нэгт. дээрх орнуудад ТББ-уудын төрийн бодлого, хууль тогтоох үйл явцад үзүүлэх үр нөлөө харьцангуй сул байна. Жишээ нь Польш улсад гэхэд л Үндэсний Эрх Чөлөө Институтын тухай хуулийг батлахад ТББ-уудын санал, дуу хоолойг огтхон ч тусгаагүй байдаг. Унгар улсад мөн адил ТББ-уудаас дэвшүүлсэн саналыг төрөөс хууль батлах үйл явцдаа тусгадаггүй хэмээжээ.

Хоёрт. Унгар болон Польш улсууд нь ТББ-ын санхүүжилт түүнд тавих хяналтыг хүчтэй хязгаарлаж байна. Харин Монгол улс тэдний адилаар санхүүжилтийг хязгаарлах хууль батлаж болзошгүй цаг үед иржээ. Унгарт төрөөс Үндэсний хамтын ажиллагааны сангийн удирдлагыг шууд томилдог учраас уг сан улс төрийн нөлөөлөлд ихээхэн автдаг аж. 2017 онд баталсан “Гадаадын дэмжлэгтэй байгууллагуудын ил тод байдлын тухай” хуулиар 23,000 еврогоос дээш санхүүжилттэй байгууллагуудыг хандивлагч бүрээ зарлахыг шаардсан ба хуулийг зөрчсөн тохиолдолд өндөр торгууль ногдуулна. ТББ-ын санхүүжилтийг эрчимтэй хянаж байгаа нь мөнгө угаах эсвэл терроризмын санхүүжилтээс сэргийлэх зорилготой хэмээн зөвтгөдөг аж. Польшийн хувьд орон нутгийн удирдлагууд нь ТББ байгуулах эрхийг олгодог ба төрийн санхүүжилтийг мөн хуваарилах үүрэгтэй. Гэвч

орон нутгийн удирдлагууд уг санхүүжилтийг буруугаар ашиглах эсвэл төрийн бодлоготой харшилсан үйл ажиллагаа явуулж буй ТББ-д олгохоос татгалздаг. 2017 онд Иргэний нийгмийн хөгжлийн төв нь ТББ-ын санхүүжилтийг төрд төвлөрүүлэх зорилготой байгуулагдсан. Тус байгууллагын удирдлагуудын дийлэнх нь Засгийн газраас томилогддог. Түүнчлэн Польшийн Засгийн газар ТББ-ыг санхүүжилтийн эх үүсвэрээ ил тод байлган хандивлагчийн талаарх мэдээллийг дэлгэхийг шаардсан Нийтийн амьдралын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Монголд 2018 оны 10-р сард ТББ-ын тухай хуулийн төслийг танилцуулсан юм. Уг төслөөр ТББ-ын санхүүжилтэд хяналт тавих зорилготой ба Иргэний нийгмийн хөгжлийн зөвлөл нь төрийн санхүүжилтийг хуваарилах үүрэгтэй. Зөвлөлийн есөн гишүүнээс дөрвийг нь Засгийн газраас шууд санал болгох бол бусад таван гишүүнийг иргэний нийгмийн байгууллагуудаас нэр дэвшүүлэх эрхтэй байхаар тусгав. Гэвч иргэний нийгмийн байгууллагуудаас нэр дэвших төлөөлөл нь зөвхөн тодорхой хэдэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байхаар заасан. Түүнчлэн уг төрийн санхүүжилтийг хуваарилах зөвлөл нь улс төрөөс хараат бус, бие даасан үйл ажиллагаагаа явуулж чадах эсэх нь эргэлзээтэй

байна. Унгар болон Польш улсын жишээн дээрээс харахад төрийн санхүүжилтийг хуваарилдаг бүтэц нь төрөөс томилогддог учир төрийн хяналт ба удирдлагад ажилладаг. Иймд санхүүжилт нь тухайн үеийн улс төрийн бодлогоос ихээхэн хамаардаг ба түүгээр ч барахгүй төрийн албан хаагчид уг санхүүжилтийг хувьдаа завших тохиолдол ч гардаг байна.

Дээрх гурван орны харьцуулсан судалгаанаас харахад залуу ардчилсан орнуудад төрийн санхүүжилт дутмаг тул санхүүжилтийн гадаад эх үүсвэр ТББ-ын хөгжилд туйлын чухал үүрэг гүйцэтгэж байна. Харьцуулсан шинжилгээгээр Унгар болон Польш орнуудад иргэний нийгэмд үзүүлж буй дарамт шахалт тун төсөөтэй. Унгар, Польш улсын төр нь ТББ-тай холбоотой хууль батлахдаа иргэний нийгмийн байгууллагуудыг төдийлөн оролцуулдаггүй, ТББ-ын санхүүжилтийг хянан шалгаж, төрийн эсрэг бодлого үйл ажиллагаа явуулж буй ТББ-ыг мэдээллийн хэрэгслээр нэр хүндийг нь унагаах зэрэг үйлдлүүд гарсаар иржээ. 2018 оноос Монгол улсад ТББ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж байгаа билээ. Уг төслөөр Монгол улс төрийн санхүүжилтийг хариуцах зөвлөлийг Унгар ба Польш улсын адилаар төрөөс хараат болгох уу үгүй юу гэдэг шийдэгдэнэ.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан
Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com